



УЛСЫН НӨӨЦИЙН САЛБАРЫН
ДАРГА Х.ЦОГБАДРАХ ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ДУНДГОВЬ АЙМГИЙН
АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

48090 Дундговь аймаг,
Сайнцагаан сум, Нарлаг баг
Утас: 70-59-24-39, 70-59-22-08, 70-59-32-08
E-mail: dundgovi@audit.gov.mn

2016.11.29 № 01/185

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.2-д заасан бүрэн эрхийн хүрээнд аймгийн Аудитын газрын 2016 оны бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Дундговь аймаг дахь Улсын нөөцийн салбарын 2016 оны 3 дугаар улиралын санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн завсрын аудитаар нийт 488,600.00 /Дөрвөн зуун наян найман мянга зургаан зуу/ төгрөгийн шатахууны зарцуулалтын тооцоог бодоогүй, акт үйлдэж баталгаажуулаагүй зөрчил илэрлээ.

Энэ нь Дэд бүтцийн сайдын 2004 оны 19 дүгээр тушаалын 1-р хавсралт /автомашины 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг нормыг үндэслэн тогтоож, мөрдөж ажиллах, шатахууны зарцуулалтын тооцоог тогтсон хугацаанд бодож, тооцоо бодсон актыг үйлдэж баталгаажуулах/-д заасныг зөрчиж байна.

Монгол Улсын Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-т /Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих/, Монгол улсын Ерөнхий аудиторовын 2014 оны 138 дугаар тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын ажилтны нийтлэг эрх, үүргийн тухай дүрмийн 2.2.3-т /Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийг хэрэгжүүлэх хүрээнд төрийн аудитын байгууллагын ахлах аудитор, ахлах шинжээч, аудитор, шинжээч нь аудитын явцад илэрсэн төлбөрийг барагдуулах, зөрчлийг арилгуулах зорилгоор төлбөрийн акт, албан шаардлага өгөх/, Монгол улсын Ерөнхий аудиторовын 2016 оны 09 дүгээр сарын 09-ны өдрийн А/95 дугаар тушаалаар баталсан Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журмын 4.1.7-д /Хууль тогтоомж зөрчсөн алдаа зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал/ заасныг тус тус үндэслэн ШААРДАХ НЬ:

1. Шатахууны зарцуулалтыг батлагдсан нормоор сар бүр бодож актаар баталгаажуулж байх,


1900000712

2. Албан шаардлагыг хэрэгжүүлж, биелэлтийг аймгийн Аудитын газарт 2016 оны 12 дүгээр сарын 10-ны дотор албан ёсоор ирүүлэхийг Улсын нөөцийн салбарын дарга /Х.Цогбадрах/, нягтлан бодогч /Б.Сайнзаяа/ нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГЫГ

ӨГСӨН¹:

Ахлах аудитор  Б.Гантуяа



ЗӨВШӨӨРСӨН:

Улсын нөөцийн салбар:

Дарга

Х.Цогбадрах

Нягтлан бодогч

Б.Сайнзаяа

¹ Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.